

## ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

2022 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр

Дугаар А/10

Улаанбаатар хот

### АГААРЫН ЗАМ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх заалт, Иргэний нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх, нислэгийн хөдөлгөөний удирдлагын сектор зохион байгуулалтыг нислэгийн төлөвлөлт, нислэгийн урсгалын эрчимжилттэй уялдуулан сайжруулах, нислэгийн аюулгүй ажиллагааг дээшлүүлэх зорилгоор Монгол Улсын агаарын зайн үзүүлэлтэд тулгуурласан навигацн бүхий агаарын замуудыг нэгдүгээр, уламжлалт агаарын замуудыг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн тогтоосугай.
2. Агаарын замуудыг шинэчлэн тогтоосныг зохих журмын дагуу зарлан мэдээлж, аюулгүй ажиллагааг ханган ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /С.Мөнхнасан/, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Зам, тээврийн хөгжлийн яамны Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Ч.Мөнхтуяа/-т тус тус даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын "Агаарын зам шинэчлэн батлах тухай" 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 317, "Тушаалын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А/02 дугаар тушаалууд тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД Л.ХАЛТАР